

**БОАЖЯМНЫ НИЙТ АЛБАН ХААГЧДЫН 2017 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

“БОАЖЯ-ны нийт албан хаагчдын 2017 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэн баталгаажуулах” ажлыг ХШҮДАГ-т үүрэг болгосны дагуу 2017 оны 12 дугаар сарын 15-29-ны өдрүүдэд яамны нийт албан хаагчдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан аргачлал, журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

2017 оны жилийн эцсийн байдлаар 9 газар, 7 хэлтсийн нийт 129 албан хаагчдаас 121-д ҮДГ-ний биелэлтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, 8 албан хаагчийн үр дүнгийн гэрээ дүгнэх хугацаа болоогүй шалтгаанаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан үзсэн болно.
Үүнд:

1. ТНБД-ын үр дүнгийн гэрээнд орсон ажлууд
2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
3. Хугацаа хоцорсон хариутай бичиг байгаа эсэх
4. 2017 оны 07 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 10-н хүртэл цагийн бүртгэл

Нийт 121 албан хаагчдын үр дүнгийн үнэлгээ 2017 оны жилийн эцэст А-22, В-80, С-18, D-1 үнэлэгдэж баталгаажсан байна.

“А” буюу “маш сайн”, “В” буюу “сайн” авсан нийт талбан хаагчдад үр дүнгийн гэрээний мөнгөн урамшуулал олгохыг санхүүгийн хэлтэст даалгасан болно.

Зөвлөмж:

- ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан БОАЖЯамны үндсэн хэрэгжүүлэх хууль, журам, аргачлал гарган батлуулах, бодлогын зорилт арга хэмжээний ажлын хэрэгжилт хангалтгүй үнэлгээтэй хэрэгжиж байгааг онцгойлон анхаарч, холбогдох мэргэжилтнүүд тусгай ажил, үйлчилгээнд тусгаж зайлшгүй хэрэгжүүлэхийг бүтцийн нэгжийн удирдлагууд анхаарч, гүйцэтгэлийг сайжруулах
- Хөдөлмөрийн хуулийн дагуу ажлын цагийг оновчтой, үр дүнтэй ашиглах, шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах, төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж хэвших
- Яаманд ирүүлсэн албан тоот, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэхэд онцгойлон анхаарах, хугацаа хэтэрсэн бичгийн бүртгэл судалгааг сар бүр гаргуулж ажиллахыг бүтцийн нэгжийн удирдлагууд анхааралдаа авч, нэгжийн дотоод хяналтыг сайжруулах
- Бүтцийн нэгжийн дарга нар болон мэргэжилтнүүд Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан аргачлал, журмын дагуу үр дүнгийн гэрээг оновчтой төлөвлөж байгуулах, тусгай болон нийт ажил, үйлчилгээг зөв эрэмбэлэн тогтоож хэрэгжүүлэх.

- Бүтцийн нэгжийн удирдлагууд үр дүнгийн гэрээ байгуулахдаа Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан аргачлал, журмыг сайтар судалж гүйцэтгэх арга хэмжээ болон хэрэгжүүлэх цаг хугацааг сайтар тооцож үр дүнтэй ажил төлөвлөж, хэрэгжилтийн үе шатанд байнгын хяналт тавьж ажиллах
- Нийт мэргэжилтнүүд салбарын бодлогын ажлыг онцгойлон анхаарч төлөвлөн, хэрэгжүүлж хэвших
- Үр дүнгийн гэрээний илтгэх хуудсанд хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн тоо, чанар, хугацаа, хүрэх түвшин, үр дүн, ажлын гүйцэтгэлийг товч, тодорхой тайлагнаж хэвших, нэгжийн дарга, удирдлагууд үнэн, бодитой дүгнэж сурах
- Бүтцийн нэгжийн дарга нар үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа хяналт-шинжилгээ хийлгэж, баталгаажуулах
- Газар, хэлтсүүд хугацаандаа бүрэн биелээгүй арга хэмжээнүүдийн тайлбар, шалтгааныг тодруулж, танилцуулга бэлтгэн Сайд,ТНБДаргад мэдээлэх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР